



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 83

Мандалговь

┌ Ундсэн хөрөнгө бүртгэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн “Приус-30” маркийн автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Оюунчимэг)-г дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 8 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын
08-ний өдрийн 8 тогтоолын хавсралт

**Сайнцагаан сумын үндсэн хөрөнгөнд бүртгэх
тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
			Сери	дугаар						
1	Суудлын	Приус-30	ДУА	07-06	2010он	2020он	100,000	15,000,000	0	15,000,000
Нийт дүн										
								15,000,000 /арван таван сая/ төгрөг		15,000,000 /арван таван сая/ төгрөг



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 84

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,000,000 /хоёр сая/ төгрөгийн балансын үнэтэй, 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 25-43 ДУА улсын дугаартай УАЗ-31512 маркийн автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Эрүүл мэндийн газрын дарга (Г.Бат-Орших)-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 7 дугаар сарын
29-ний өдрийн 84 тогтоолын хавсралт



Эрүүл мэндийн газрын дуудлага худалдаанд, худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Дуудлага худалдааны үнэ
			Сери	дугаар						
1	Суудлын	УАЗ-31512	ДУА	25-43	2002	2003.01.23	91904	2,000,000	1,500,000	1,500,000
Нийт дүн										1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг
										1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 85

Мандалговь

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад ┐ шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 78,190,000 /далан найман сая нэг зуун ерэн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 48,220,556 /дөчин найман сая хоёр зуун хорин мянга таван зуун тавин зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга (Д.Ганбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хошууч (Н.Есөн-Эрдэнэ) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 8 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 7 дугаар сарын
18-ны өдрийн 8 тогтоолын хавсралт

**Аймгийн Засаг даргын тамгын газрын балансаас балансад
шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Хүлээн авах байгууллага	
			Сери	дугаар							
1	Суудал	Тоёота ланг круйзер-100	ДУА	00-05	2006	2017.11.02	181,129	49,500,000	22,000,000	Ду.ШШГГазар	
2	Суудал	УАЗ-Пургон	ДУА	00-48	2011	2019.06.10	125,393	14,345,000	3,984,722	Эрдэнэдалай сумын засаг даргын тамгын газарт	
3	Суудал	УАЗ-Пургон	ДУА	00-49	2011	2019.06.10	97,790	14,345,000	3,984,722	Ус суваг ОНӨГ	
Нийт дүн											
								78,190,000 /далан	29,969,444		
								найман сая нэг зуун ерэн мянга /төгрөг	есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун дөчин төгрөг		



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 86

Мандалговь

Г Зарим албан тушаалтныг үүрэгт ажлаас
чөлөөлөх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Дундговь-Ус ОНӨҮГ-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Сүхбаатар, Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨҮГ-ийн дарга М.Сосорбурам, Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨҮГ-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Н. Мятагмаа, НҮҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Гантогтох нарын хүсэлтийг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас 2020 оны 07 дугаар сарын 29 ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

Хоёр: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С. С. С. СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 87

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Луус сумын малчин, өндөр настан Хондогойгийн Сугирыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 87

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Хөдөө аж ахуйн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Луус сумын малчин, өндөр настан Хондогойгийн Сугирыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 88

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Сайнцагаан сумын өндөр настан Зэвэгийн Цэрэндоржийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР





ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 89

Мандалговь

┌ Монгол Улсын цол хүртээх, одон, ┐
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА С. СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын
29 ны өдрийн 2 тогтоолын хавсралт



“Алтан гадас одон”-гоор:

1. Дашмаагийн Эмгээ- Сайнцагаан сумын иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч
2. Самаагийн Норсүрэн –Дэлгэрцогт сумын ахмад настан

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:

1. Цэрэнбатын Энхтуяа – Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн
2. Төмөр-Өлзийгийн Эрдэнэсүх – Сайнцагаан сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн
3. Дашдондогийн Уранбаяр – Дундговь аймгийн Автотээврийн төвийн нягтлан бодогч
4. Сосорын Цэрэн-Янжин-Баянжаргалан сумын ЕБС-ийн захирал



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 89

Мандалговь

┌ Монгол Улсын цол хүртээх, одон, ┐
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.


Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны ... дугаар сарын
29... ны өдрийн ... тогтоолын хавсралт



“Алтан гадас одон”-гоор:

1. Дашмаагийн Эмгээ- Сайнцагаан сумын иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч
2. Самаагийн Нурсүрэн –Дэлгэрцогт сумын ахмад настан

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:

1. Цэрэнбатын Энхтуяа – Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн
2. Төмөр-Өлзийгийн Эрдэнэсүх – Сайнцагаан сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн
3. Дашдондогийн Уранбаяр – Дундговь аймгийн Автотээврийн төвийн нягтлан бодогч
4. Сосорын Цэрэн-Янжин-Баянжаргалан сумын ЕБС-ийн захирал



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 90

Мандалговь

Аймгийн сонгуулийн хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.5 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн сонгуулийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Самданцоодол / аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга/

Гишүүд: А.Нарантуяа / аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга /

Ш.Нарангэрэл / аймгийн УБХ-ийн ЭХЭУБ-ийн тасгийн дарга

А.Ууганбаяр / Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын дарга /

С.Цэнгэлмаа / аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн ахлах

мэргэжилтэн

Ж.Түмэндэлгэр / аймгийн ИТХ-ын ахлах мэргэжилтэн /

Нарийн бичгийн дарга: Ц.Ганзориг / Аймгийн ГБХЗХГ-ийн дарга /

Хоёр Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг холбогдох хуулийн дагуу зохион байгуулан ажиллахыг аймгийн Сонгуулийн хорооны дарга / Г.Самданцоодол/-д даалгасугай.

Гурав: Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 91

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 10 дугаар зүйлийн 10.1, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын 3.7, 3.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 01 дүгээр хавсралтаар, Ажлын хэсгийн ажиллах журмыг 02 дугаар хавсралтаар, Ажлын хэсгийг мэдээллээр хангах журмыг 03 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч / О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Гурав. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолыг тус хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 29 -ний
өдрийн 97 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР
ХАНГАХ ОРОН ТООНЫ БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ахлагч: -Аймгийн Засаг дарга
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд: -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргаа удирдлагын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн
дарга
- Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
/Зөвшилцсөнөөр/
- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
/Зөвшилцсөнөөр/
- Тагнуулын ерөнхий газрын Дундговь
аймаг дахь хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Зэвсэгт хүчний 278 дугаар ангийн захирагч
-Аймгийн Татварын хэлтсийн дарга

- Гадаадын иргэний харьяатын газрын
Дундговь аймаг дахь төлөөлөгч
- Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга
- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Аймгийн Мал эмнэлэгийн газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
дарга
- Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
- “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ийн
Дундговь аймгийн салбарын дарга
- БНЗӨБЦТС ТӨХК-ийн Дундговь аймаг дахь
салбарын захирал
- “Дундговь Ус” ОНӨҮГ-ийн захирал
- Хот тохижуулах газрын дарга
- Монгол банкны Дундговь аймаг дахь салбарын
захирал
- Аймаг дахь Авто тээврийн төвийн дарга

--- оОо ---

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ
МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

1.2. Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн дарга, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан албан тушаалтан, өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан албан тушаалтан, Ажлын хэсгийн гишүүдийн эрхэлдэг үндсэн албан тушаалын тодорхойлолтод Ажлын хэсгийн шугамаар хэрэгжүүлэх чиг үүргийг тусгаж, эрх бүхий этгээдээр баталгаажуулна.

1.3. Ажлын хэсэг нь өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна.

Хоёр. Ажлын хэсгийн эрх, үүрэг

2.1. Орон нутгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

2.2. Орон нутагт үйл ажиллагааг явуулж буй үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

2.3. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, шалтгаан нөхцлийг судлан тогтоох, арилгахад орон нутгийн удирдлагад дэмжлэг үзүүлэх;

2.4. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардлыг улсын болон орон нутгийн төсөв, төсвөөс гадуурх хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлүүлэх зорилгоор холбогдох байгууллагад санал хүсэлт тавих;

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний эрх, үүрэг

3.1. Ажлын хэсгийн ахлагчийн эрх, үүрэг:

3.1.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны зорилго, стратегийг тодорхойлж, хэлэлцүүлэх;

3.1.2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.1.3. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох, хөтөлбөрийг батлах, хуралдааныг даргалах, шийдвэр гаргах;

3.1.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг танилцуулах;

3.1.5. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хурлаас баталсан бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, биелэлтийг хагас жил тутамд тайлагнах;

3.1.6. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг эрх бүхий этгээдэд тавих;

3.1.7. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан товлосон хугацаанаас өмнө Ажлын хэсгийн хуралдааны товыг зарлаж, шуурхай хуралдуулах;

3.1.8. Нутаг дэвсгэрийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны жилийн нэгдсэн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангаж, ажиллах;

3.2 Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргын эрх, үүрэг:

3.2.1. Ажлын хэсгийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Ажлын хэсгийн ахлагчид тухай бүрт нь тусалж, хамтарч ажиллах;

3.2.2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулах, хэлэлцүүлэх, Ажлын хэсгийн ахлагчаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.2.3. Шуурхай мэдээ, яаралтай мэдээ, хагас жилийн мэдээ, жилийн эцсийн мэдээ, тайлан, илтгэлийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Ажлын албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.4. Ажлын хэсгийн ахлагчийн эзгүй байх үед Ажлын хэсгийн үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах;

3.2.5. Хагас жил болон жилийн эцсийн тайлан, мэдээ, үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг боловсруулж, Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.2.6. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан ажилтан, өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан албан тушаалтан нарын үндсэн үүрэгт ажлыг нь алдагдуулалгүйгээр чиглүүлэх;

3.3 Ажлын хэсгийн гишүүний эрх, үүрэг:

3.3.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, хариу мэдээлэх, тайлагнах;

3.3.2. Өөрийн байгууллагын хариуцсан ажлын чиглэлээр Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа, нөхцөл байдлын талаар Ажлын хэсэгт дүгнэлт, санал бүхий мэдээлэл танилцуулах;

3.3.3. Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй тухай илтгэлийг боловсруулах ажилд оролцох;

3.3.4. Ажлын хэсгийн хуралдаанд хэлэлцэх сэдэв, асуудлын санал оруулах;

3.3.5. Хуралдаанд оруулах бүрэлдэхүүний талаар Ажлын хэсгийн ахлагчид санал оруулж, шийдвэрлүүлэх;

3.3.6. Ажлын хэсгээс гарсан шийдвэрийг биелүүлж, хариу тайлагнах;

Дөрөв. Өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан албан тушаалтны эрх, үүрэг

4.1. Аймаг, орон нутагт болсон онцгой үйл явдал, цаг үеийн нөхцөл байдлын тухай шуурхай мэдээ болон яаралтай мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Шуурхай мэдээ хариуцсан референтэд хоногт 2 удаа мэдээлэх;

4.2. Төрийн байгууллага, албан тушаалтнаас өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг гаргуулан авах;

4.3. Хариуцсан ажлын чиглэлээр бүртгэл, судалгааг хөтлөх;

**Тав. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан
албан тушаалтны эрх, үүрэг**

5.1. Байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээ, тайланг Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн даргад танилцуулах;

5.2. Холбогдох мэдээ, тайланг нэгтгэн боловсруулж, удирдах албан тушаалтанд танилцуулж, зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Ажлын албанд хүргүүлэх;

5.3. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар байгууллага, албан тушаалтныг холбон ажиллах;

5.4. Ажлын хэсгийн болон төрийн бусад байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээ, тайлан, судалгааны баримт бичгийг нэгтгэн боловсруулах, бүртгэл хөтлөх;

5.5. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл хөтөлж, албажуулах;

Зургаа. Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар

6.1 Ажлын хэсэг нь улирал бүр тухайн улиралын эхний сарын 15-ны дотор хуралдах бөгөөд эхний хагас жилийн хурлыг 06 дугаар сарын 15-наас өмнө, жилийн эцсийн хурлыг 12 дугаар сарын 10-наас өмнө хуралдуулна.

6.2. Ажлын хэсэг хэлэлцэх асуудалтай холбогдуулан хаалттай хуралдаж болно. Хаалттай хуралдааны нууцлал, аюулгүй байдлыг Ажлын хэсгийн ахлагч, хариуцан ажиллана.


6.3 Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн дарга нар Ажлын хэсгийн хуралдаанд оролцох гишүүдийн тоог хязгаарлах, эсвэл өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулахыг хэлэлцэх асуудлыг санал оруулсан гишүүний саналыг үндэслэн зөвшилцөж шийдвэрлэнэ.

6.4. Үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор Ажлын хэсгийн хуралдааныг ээлжит бусаар хуралдуулж болно.

6.5. Ажлын хэсгийн хуралдаанаас тэмдэглэл гарах бөгөөд энэ нь заавал хэрэгжүүлэх шинжтэй байна.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



АЖЛЫН ХЭСГИЙГ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг”/-ийг мэдээллээр хангах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Ажлын хэсгийг мэдээллээр хангах тогтолцоо

2.1. Ажлын хэсгийг мэдээ, мэдээллээр хангах үүргийг орон нутагт дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй болон төрийн бусад байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, хуулийн бусад этгээд хүлээнэ.

2.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Ажлын хэсгийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэй.

2.3 Ажлын хэсэг нь шаардлагатай бол үндэсний ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагаас шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авна.

Гурав. Мэдээ, мэдээллийн ангилал, хугацаа

3.1 Ажлын хэсэгт ирүүлэх мэдээлэл нь шинж чанараасаа хамааран Яаралтай мэдээ, Шуурхай мэдээ, Танилцуулах мэдээ, тайлан гэсэн төрөлтэй байна. Үүнд:

3.1.1 “Яаралтай мэдээ” гэж үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд хохирол учруулахуйц үйл явдлын тухай мэдээ болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс албан хэрэгцээнд нэн даруй ирүүлэхийг шаардсан мэдээг;

3.1.2 “Шуурхай мэдээ” гэж тухайн үед болсон үйл явдал, хэргийн талаарх мэдээг;

3.1.3 “Танилцуулах мэдээ” гэж үйл явдлын товч танилцуулга, тодорхой санал бүхий мэдээллийг;

3.1.4 “Тайлан мэдээ” гэж үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг тухайн салбар, байгууллагын хүрээнд хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлсэн, гарсан үр дүнгийн тухай тайланг;

3.2 Яаралтай мэдээг Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалт хариуцсан мэргэжилтэн холбогдох утсаар эсвэл биечлэн дамжуулна.

3.3. Аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтан эрхэлсэн ажлын хүрээнд өдөр тутмын нөхцөл байдлын талаар Цэргийн штабт мэдээлнэ.

3.4. Төрийн байгууллага, албан тушаалтнууд Ажлын хэсэгт ирүүлэх мэдээг заагдсан хугацаанд ирүүлнэ.

Дөрөв. Мэдээ, мэдээлэл ирүүлэх

4.1. Төрийн байгууллагууд энэхүү журмын хавсралтад заасан мэдээллийг Ажлын хэсэгт бичгээр ирүүлнэ. Мэдээллийг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан бичгээр шуудангаар, биечлэн эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

4.2. Бичгээр хүргүүлж байгаа мэдээллийг цахим хэлбэрээр /Flash, CD гэх мэт/ хавсаргасан байна. Ингэхдээ мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг авсан байна.

4.3. Мэдээлэл нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчимд тулгуурласан, бодит мэдээлэлд үндэслэсэн, цэгцтэй, товч, тодорхой, цаг үеэ олсон байна. Энэхүү журмын хавсралтад заасан төрийн байгууллага, албан тушаалтан нь заасан хугацаанд мэдээллийг Ажлын хэсэгт ирүүлсэн байна.

4.4. Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан Ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцсан ажилтныг томилж, түүний гүйцэтгэх үүргийг албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгана.

4.5. Ажлын хэсгийг мэдээллээр хангах үүргийн дагуу Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн даргын албан бичгээр шаардсан мэдээ, мэдээллийг шаардсан хэлбэрээр холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан тогтоосон хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

4.6. Энэхүү журмын хавсралтад заагаагүй мэдээ, мэдээлэл, санал, судалгааг Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн даргын үүрэг, чиглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд ирүүлэх үүрэгтэй.

4.7. Энэхүү журмын дагуу хүлээн авсан мэдээллийг зөвхөн Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж, нууцлалыг чанд хадгална.

4.8. Төрийн болон албаны нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг боловсруулах, илгээх, хүлээн авах, ашиглах, хадгалахдаа Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын дагуу гүйцэтгэнэ.

4.9. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолд зааснаар мэдээний нууцын зэрэглэлийг илгээгч байгууллага шийдвэрлэнэ.


Тав. Хариуцлага

5.1. Ажлын хэсэгт ирүүлсэн мэдээллийн үнэн бодит байдлыг илгээгч байгууллага, албан тушаалтан, этгээд хүлээнэ.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

--- оОо ---

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 29 -ний
2020 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар батлагдсан
Ажлын хэсгийг мэдээллээр хангах журмын хавсралт



АЖЛЫН ХЭСЭГТ ИРҮҮЛЭХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

№	Мэдээлэл ирүүлэх байгууллага	Ирүүлэх мэдээ	Мэдээний ангилал	Хугацаа
1	Аймгийн ИТХ-ын Ажлын алба	Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага, сүм, хийдийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, байгуулсан хэлэлцээр, гэрээ, санамж бичгийн хуулбар	Тэмдэглэлийн хуулбар	Тухай бүр
3	Цэргийн штаб	Батлан хамгаалах талаарх бодлого, үйл ажиллагааг иргэдэд сурталчилсан тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшүүлэх чиглэлээр зохиосон ажил	Тайлан	Хагас жил тутам
4	Аймгийн Прокурорын газар	Төрийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн талаар	Танилцуулах тойм мэдээ	Тухай бүр хагас жилдээ
5	Тагнуулын хэлтэс	Аймаг орон нутаг үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлын мэдээ, хүчин зүйлс, тэдгээрээс сэрэмжлүүлэх арга хэмжээний санал	Шуурхай мэдээ, Танилцуулах мэдээ	Тухай бүр
6	Цагдаагийн газар	Орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргийн болон хэв журмын зөрчлийн тоо, тэдгээрийн төрөл, хүн амины санаатай болон онц хүнд, зохион байгуулалтай гэмт хэргийн талаар	Шуурхай мэдээ	Тухай бүр
		Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын тухай өдөр тутмын мэдээ	Шуурхай мэдээ	Тухай бүр
		Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлсэн ажлын тухай	Танилцуулах мэдээ	Улиралд бүр
		Эрэн сурвалжлагдаж буй хүн, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, химийн цацраг идэвхт бодисыг олж тогтоосон, эдгээртэй холбоотой гэмт хэргийн тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын тухай	Танилцуулах мэдээ	Сар бүр
7	Онцгой байдлын газар	Өдөр тутмын нөхцөл байдлын тухай	Шуурхай мэдээ	Тухай бүр улирал

			Танилцуулах мэдээ	тутам
		Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулсан тухай мэдээ	Тайлан	Тухай бүр
		Аюулт үзэгдэл, үйлдвэрлэлийн ослын тухай	Шуурхай мэдээ	Тухай бүр
		Аюулт үзэгдэл зэрэг байгалийн гамшиг, түүний хор уршиг, нийгэм, эдийн засагт учруулсан хохирлын тухай	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
8	Улсын бүртгэлийн хэлтэс	Хүн амын шилжилт, хөдөлгөөний тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Хүн амын төрөлтийн өсөлт, бууралтын тухай	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Шашны байгууллага, сүм хийд, төрийн бус байгууллагуудын тухай	Танилцуулах мэдээ	Улирал бүр
9	Мэргэжлийн хяналтын газар	Химийн хортой, мансууруулах, тэсэрч дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалтын тухай	Танилцуулах мэдээ	Сар бүр
		Тэсэрч, дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
		Ашигт малтмалын хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, уурхайн талбайн нөхөн сэргээлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Амьдрах орчны аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Эрүүл мэндийн салбарын эмчилгээ, оношлогооны чанарын хяналтын үйл ажиллагааны тухай	Танилцуулах мэдээ Тайлан	Хагас жил тутам
		Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт, үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан хэрэг зөрчлийн тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр
10	Татварын хэлтэс	Татварын орлогын төвлөгөөний биелэлт /нэгдсэн болон салбар бүрээр/	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн төсөвт оруулсан татварын талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
11	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгаль орчны төлөв байдал, экосистемийн өөрчлөлт, хүн, малын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, эрсдэл, тулгамдсан асуудал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүн, ундны усны нөөц, байгалийн баялагийн хомсдлын тухай	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Байгалийн нөөц ашиглалт хамгаалалт нөхөн сэргээлтийн тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт,	Танилцуулах	Хагас жил

		хуурайшилтын өнөөгийн болон хэтийн төлөв, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын хэрэгжилтийн талаар	мэдээ	тутам
		Ховор, нэн ховор устгах аюулд орсон амьтан, ургамлын төрөл зүйлийн хамгаалал, өсгөн үржүүлэлт, тэдгээрийн тооллогын талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Хүн амын ундны усны хангамж, эрүүл ахуйн чанар, үйлдвэрлэлийн усны хангамж, боломжит нөөцийн байдлын талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Аялал жуучлалын салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ, аялал жуучлалын бүтээгдэхүүн, аялал жуучлалын байгууллагын талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
12	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, газрын нэгдмэл сан, ангилал тус бүрийн талбай, газрын төлөв байдлын мэдээ, судалгаа зураглал /зурган мэдээний хамт/	Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Аймгийн хэмжээнд барилгын салбарт улсын төсөв, гадаадын болон дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тэдгээрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болон ажлын гүйцэтгэлийн мэдээ, судалгаа	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
13	Боловсрол, соёл урлагийн газар	Эх оронч, үндэсний үзэл, хүмүүжил, төлөвшүүлэх чиглэлээр зохиосон ажлын тайлан	Тайлан	Хагас жил тутам
		Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт явцын тухай мэдээ тайлан	Тайлан	Хагас жил тутам
14	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Бэлчээр ашиглалт, бэлчээрийн усан хангамжийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тухай	Тайлан	Хагас жил тутам
15	Мал эмнэлэгийн газар	Мал, аж ахуйн бодлогын хэрэгжилт, малын тоо, өсөлт, хорогдол, үржлийн бодлого, сүргийн бүтцийн тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Мал, амьтны гоц халдварт болон халдварт, паразит, халдваргүй өвчний талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
		Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
16	Эрүүл мэндийн газар	Хүн амын өвчлөл, эндэгдлийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам

		Төрөл ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис хэрэглэх, донтох, эмгэг сэтгэцийн эмгэг, зан үйл, оюуны хомсдолтой хүмүүсийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Шинээр болон сэргэн тархаж буй халдварын болзошгүй аюулаас сэргийлэх, хариу арга хэмжээ, халдвар, хордлогын өвчлөл, эрсдлийн тухай	Шуурхай мэдээ Тайлан	Тухай бүр Жил бүр
		Товлолын болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын талаар	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Тухай бүр Хагас бүр
		Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн төлөв байдлын тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх, үйл ажиллагааны үзүүлэлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
17	Гадаадын иргэн, харьяатын газрын Дундговь аймаг дахь төлөөлөгч	Гадаадын иргэдийн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн мэдээ болон албадан гаргасан иргэдийн талаар	Шуурхай мэдээ	Тухай бүр
		Гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагуудын төлөөлөгч нарын газрын тоо, байршил, судалгааны талаар	Танилцуулах тойм мэдээ	Улирал бүр
		Монгол Улсад ажил үйлчилгээ явуулж байгаа гадаадын иргэдийн судалгаа	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Харьяалалгүй хүмүүсийн тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
18	Ус цаг уур, орчны шинжилгээний газар	Байгаль, цаг агаарын онц аюултай гамшигт үзэгдлийн тухай	Шуурхай мэдээ	Тухай бүр
19	Статистикийн хэлтэс	Нийгэм, эдийн засгийн төлөв байдлын тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнэ ханш, статистикийн үзүүлэлтийн талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
20	Стандарт хэмжил зүйн хэлтэс	Монгол Улсын үндэсний стандартыг олон улсын стандартын түвшинд нийцүүлж байгаа талаар /салбар тус бүрээр/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутамд
		Монгол Улсад мөрдөгдөж буй олон улсын стандартын хэрэгжилтийн талаар /салбар тус бүрээр/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
21	БНЗӨБЦТС ТӨХК-ийн Дундговь аймаг дахь салбар	Түлш, эрчим хүчний салбарын эрсдлийн үнэлгээ, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн төлөв байдлын тухай мэдээ, судалгаа	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
22	“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ийн	Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, илэрсэн зөрчлийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам

	Дундговь аймгийн салбар	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар	Тайлан	Хагас жил тутам
24	“Дундговь- Ус” ОНӨУГазар	Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн тухай /зураглал, зурган мэдээллийн хамт/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Ундны усан хангамжийн талаар	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
25	Холбооны газар	Олон улсын байгууллагуудаас мэдээллийн салбарт хэрэгжүүлж буй төслийн явцын тухай	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, хийсэн ажлын талаар	Тайлан	Улирал бүр
26	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	Хүн амын амьжиргааны түвшний тухай /хувиар/	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн бүтэц, салбар бүрээр, хүйс, насны ангилалын талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Асрамжийн үйлчилгээнд байгаа, хүнд нөхцөлтэй 18 хүртлэх насны хүүхдийн тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
27	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Төрөөс хэрэгжүүлж буй гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх, нийгмийн дэмжих бодлогын хэрэгжилтийн тухай	Тайлан	Хагас жил тутам
28	Төрийн аудитын газар	Хяналт шалгалтаар илрүүлсэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлт үйл явдлын тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр
29	Авто тээврийн төв	Аймгийн зам харилцаа, авто тээврийн үйл ажиллагаа, эрсдэлт хүчин зүйлийн талаар	Танилцуулах мэдээ	Тухай бүр
30	Монгол банкны аймаг дахь салбар	Банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа, тулгамдаж буй эрсдэл, төрийн мөнгөний бодлогод сөрөг нөлөөтэй хүчин зүйлсийн тухай	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Банкны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
31	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Хөрөнгө оруулалтын статистик үзүүлэлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутамд
		Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, олгож буй зээл, түүний үр ашиг, эргэн төлөлтийн тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Ашигт малтмалын үнэ, олборлолт, зах зээлийн судалгааны талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр

		Хайгуулын томоохон төслүүдийн талаарх мэдээ	Танилцуулах мэдээ	Улирал бүр
32	Нийгмийн даатгалын хэлтэс	Хөдөлмөрлөх хүчний хангамж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дадлагын болон ажлын байраар хангагдсан төлөв байдлын талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Нийгмийн даатгалын сангийн талаар	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам

---o0o---